



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 17 өдөр

Дугаар А/583

Номгон

“Газар эзэмших эрхийн гэрчилгээт дуудлага”
худалдаа зохион байгуулах комисс томилох
тухай

“Газрын тухай” хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээт цахим дуудлага худалдаа зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга А.Цэцэнбилэг – Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга О.Мөнхцэцэг – Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн


Гишүүд: Э.Сэмбэсүрэн–Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Ж.Лхамдулам– Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

2.Дуудлага худалдааг 2021 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр Газрын цахим бирж MLE.mn сайтаар цахимаар зохион байгуулж, үр дүнг дуудлага худалдаа явуулснаас хойш ажлын 14 хоногт багтаан Засаг даргын зөвлөлд танилцуулахыг дуудлага худалдааны комисст үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601210363